



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАРТ

"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
"Урбанек" ХХК-ийн байр 306, 307 тоот
Утас: 324338, 89116465, 98056465, 99095580
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2024-05-08 № 01/33
танай _____-ны № _____-т

Аудитын дүгнэлт өөрчлөх
тухай

"Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК нь 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр манай байгууллагатай Аудитын үйлчилгээ үзүүлэх 2024/53 дугаартай гэрээ байгуулж, гэрээний дагуу 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэхээр холбогдох материалыг 4 дүгээр сарын 10-наас эхлэн ирүүлсэн боловч, санхүүгийн тайлан алдаатайгаас олон удаа засварласан, нотлох баримтуудыг бүрэн ирүүлээгүйгээс дутуу баримтуудыг шаардсаар байтал цаг хугацаа шахуу болж урьдчилсан байдлаар Зөрчилгүй дүгнэлт гаргасан.

Удирдлагад хүргэх захидал, зөвлөмж бичих, хожуу ирүүлсэн баримтуудыг шалгах явцад авлага, өглөгийн үлдэгдлүүд бүрэн баталгаажаагүй, нотлох баримтууд хүчин төгөлдөр бус байсан нь дүгнэлтийн хэлбэрийг өөрчилж Хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл болж байна.

Иймд өөрчилсөн дүгнэлтийг хүлээн авна уу.

Хувийг: "Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК-д

ЗАХИРАЛ



Ж.ОЮУНЦЭЦЭГ



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

“БЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
“Урбанек” ХХК-ийн байр 306, 307 тоот
Утас: 324338, 89116465, 98056465, 99095580
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2024, 05.09 № 101

танай _____ -ны № _____ -т

ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бид “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын гол асуудалд дурьдсан авлага, өглөгтэй холбоотой алдаа, зөрчлийг эс тооцвол “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн тул Хязгаарлалттай дүгнэлт гаргаж байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Авлага, өглөг, урьдчилж төлсөн тооцооны үлдэгдэлд тооцоо бүрэн нийлж баталгаажуулаагүй,
- “Хувьцаат орон сууц” хөтөлбөр зорилгын дагуу хэрэгжээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх

хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ЗАХИРАЛ



Ж. ОЮУНЦЭЦЭГ

"Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөг)

Үзүүлэлтүүд	2022.12.31	2023.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	197,803,408.26	1,601,533.20
Дансны авлага	1,470,901,128.51	2,770,729,550.00
Татвар, НДШ-ийн авлага	4,950,767.33	
Бусад авлага	361,965,857.00	
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	321,171,880.00	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,319,053,564.00	504,942,350.00
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн		
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,675,846,605.10	3,277,273,433.20
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,578,367,004.32	58,213,901.65
Биет бус хөрөнгө	36,545,000.00	8,600,000.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,787,544,681.81	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,402,456,686.13	66,813,901.65
Нийт хөрөнгийн дүн	12,078,303,291.23	3,344,087,334.85
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,553,896,983.36	1,889,079,762.00
Цалингийн өглөг	5,151,078.40	
Татварын өглөг	33,157,987.62	45,916,550.45
НДШ-ийн өглөг	16,098,902.04	67,007,752.88
Богино хугацаат зээл	612,548,799.00	
Холбоотой талд өгөх өглөг		3,174,542,384.35
Урьдчилж орсон орлого		
Бусад богино хугацаат өр төлбөр	643,350.00	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,221,497,100.42	5,176,546,449.68
Урт хугацаат зээл	657,715,000.00	
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр	9,549,504,419.04	
Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,207,219,419.04	-
Өр төлбөрийн нийт дүн	13,428,716,519.46	5,176,546,449.68
Эзэмшигчийн өмч		
Өмч: а) Төрийн	-	-
б) Хувийн	5,205,601.00	5,205,601.00
в) Хувьцаат		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,355,618,829.23)	(1,837,664,715.83)
Эзэмшигчийн өмчийн дүн	(1,350,413,228.23)	(1,832,459,114.83)
Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	12,078,303,291.23	3,344,087,334.85

БЭСТ ФОРТУНА
АУДИТ ХХК

Б.С. сар
Ө.С. өдөр

"Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	(төгрөг)	
Үзүүлэлтүүд	2022.12.31	2023.12.31
Борлуулалтын орлого		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
Нийт ашиг (алдагдал)	-	-
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого		
Ноогдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	534,266,600.68	482,045,886.60
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(534,266,600.68)	(482,045,886.60)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(534,266,600.68)	(482,045,886.60)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(534,266,600.68)	(482,045,886.60)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
Бусад олз (гарз)	-	
Орлогын нийт дүн	(534,266,600.68)	(482,045,886.60)
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХК 05 сар 08 өдөр

"Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,205,601.00	-	-	(821,352,228.60)	(816,146,627.60)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(534,266,600.68)	(534,266,600.68)
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,205,601.00	-	-	(1,355,618,829.23)	(1,350,413,228.23)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл	5,205,601.00				5,205,601.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(482,045,886.60)	(482,045,886.60)
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,205,601.00	-	-	(1,837,664,715.83)	(1,832,459,114.83)

БЭСТ ФОРТУЛА
АУДИТ ХАК
05 сар
08 өдөр

"Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН
ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(төгрөг)

Үзүүлэлтүүд	2022.12.31	2023.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	4,656,645,403.00	1,921,159,296.43
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	36,342,201.00	-
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	4,620,303,202.00	1,921,159,296.43
Мөнгөн зарлагын дүн (-)	2,772,856,626.00	169,471,021.77
Ажиллагсад олгосон мөнгө	97,203,105.00	258,410,980.36
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	15,842,200.00	29,717,262.73
Бараа, материал худалдан авахад төлсөн	1,471,592,505.00	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэгт төлсөн	3,160,000.00	9,542,378.00
Ашиглалтын зардалд төлсөн	80,901,502.00	54,000,000.00
Хүүний төлбөрт төлсөн	4,161,405.00	104,512,754.82
Татварын байгууллагад төлсөн	3,511,807.00	-
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	1,096,484,102.00	(286,712,354.14)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,883,788,777.00	1,751,688,274.66
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	2,228,932,207.00	1,947,890,110.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,228,932,207.00	1,947,890,110.00
Бусад мөнгөн зарлага	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,228,932,207.00)	(1,947,890,110.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	474,000,000.00	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	474,000,000.00	-
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн мөнгө	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	474,000,000.00	-
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	128,856,570.00	(196,201,835.34)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,946,760.54	197,803,368.54
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,803,368.54	1,601,533.20